

Үйл үг бүтээх дагаврын утга, үүргийг тодруулах нь (Хорин нэгт тайлбар толийн жишээн дээр)

Пүрэвдоржийн Эрдэнэтуяа 

Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн
Монгол хэлний тэнхимийн багш, доктор (Ph.D), дэд профессор, Улаанбаатар, Монгол Улс

Өлзийн Үзэсгэлэн

Өвөр Монголын Багшийн Их Сургуулийн Эрэн хот олон улсын дээд сургуулийн Монгол
хэлний тэнхимийн багш, МУБИС-ийн Монгол хэлний тэнхимийн докторант, Хятад Улс

Хүлээн авсан - Received:
2023-11-08

Засварласан - Revised:
2023-12-18

Хэвлэгдсэн - Published:
2023-12-26

erdenetuya@msue.edu.mn

ORCID: [0000-0002-9721-3517](https://orcid.org/0000-0002-9721-3517)



© 2023, Author(s)

Хураангуй: Энэхүү өгүүлэлд монгол хэлний ууган тайлбар толь болох Хорин нэгт тайлбар толь бичиг (1717)-ийн баримтад тулгуурлан, монгол хэлний үйл үг бүтээх онцлог, содон дагаврыг үгийн бүтэц, хэв шинжийн үүднээс тайлбарлав. Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтээх дагаврыг идэвхтэй язгуураас үйл үг бүтээх, идэвхгүй язгуураас үйл үг бүтээх гэж хоёр ангилна. Хорин нэгт тайлбар толийн баримтаас үзэхэд идэвхтэй язгуураас үйл үг бүтээх “-la” дагаврын хувилбар “-lo (u)”, “-lü” дагавар, “-na” дагаврын хувилбар “-no (u)”, “-nü” гэсэн өвөрмөц дагавар буйг толь бичгийн баримтаас эшлэн тайлбарлав. Мөн чөлөөт бус язгуураас үйл үг бүтээх “-ra, -ro, -ri”, “-γa⁴ + na⁴”, “-l”, “-ci-” гэсэн дагаврыг үгийн бүтцээр задлан тайлбарлав.

Түлхүүр үг: Үйл үг, үйл үг бүтэх ёс, идэвхтэй язгуур, чөлөөт бус язгуур, дагавар, дагаврын хувилбар

Удиртгал

Аливаа хэлний үйл үг нь тухайн хэлнийхээ бүтэц, тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тоо хэмжээний хувьд нэр үгээсээ цөөн боловч идэвхтэй хэрэглэгддэг бөгөөд ялангуяа, хэлний төгс дохио болох өгүүлбэрийг бүтээх, түүний бүтэц дэх үгийн хэл зүйн хэлбэржилтийг тогтоох тулгуур нь болдог. Үйл үгийг хэл шинжлэлийн нэвтэрхий тольд үйл үг (лат. *verbum*)-үйл хөдлөл (тодорхой цаг хугацаанд болж байгаа үйлийн хөдлөнгө шинж)-ийн хэл зүйн утга илтгэж, өгүүлбэрт ихэвчлэн өгүүлэхүүний үүрэг гүйцэтгэдэг үгийн аймаг юм. Өгүүлэхүүн чанар илтгэдэг онцлог шинжээрээ үйл үг нь нэр үг (жинхэнэ нэр)-тэй эсрэгцдэг тул нэн

эртний (Платоны бүтээлд ч) грек, энэтхэг, арабын болон бусад хэл шинжлэлийн уламжлалаас эхлэн нэр үг, үйл үг гэж ангилж иржээ (Өнөрбаян ба бус, 2022: 122).

Үг бүтэх ёс нь үгийн сан, хэл зүй хоёрын аль алиных нь шинжийг хадгалсан, эл хоёр түвшний зааг дээр орших салбар ухаан учраас түүнийг тодорхойлох, хамрах хүрээг нь тогтоохдоо ч дээрх онцлогийг харгалзаж үзсээр иржээ. Тиймээс үг бүтэх ёс нь өргөн утгаараа үгийн бүрэлдэхүүн дэх бүтээврийн өөрчлөлтийн бүхий л үйл явцыг хамрах бөгөөд үг бүтэх, үг хувилах ёс хоёулаа багтана (Өнөрбаян ба бус, 2022: 195).

Аливаа хэлний үйл үг нь тухайн хэлний уугуул үг байх ба үгийн сангийнхаа үндсэн гол хэсгийг бүрдүүлдэг. Аливаа хэлний үг бүтэх ёс нь үгийн бүтэц хэв шинж, хэл зүйн байгууллагаас хамааран, дэлхийн олон хэлнүүдэд харилцан адилгүй байдаг. Түүнчлэн хэл шинжлэлд “Хэлний үгийн тоо нь хэлний ертөнцийн хэмжээг илтгэнэ. Хэл зүйн байгуулал нь сэтгэхүйн дотоод байгууллыг төсөөлөхөд тусална”, “Хэлний үгийн сан хөмрөг нь хүмүүс юуны тухай бодож байгааг, харин хэл зүй нь хэрхэн бодож байгааг илтгэнэ” (Цог-Очир, 2018: 428) гэсэн онолын үндэслэл байдаг. Ийм учраас хэлний үг бүтэх ёс нь тухайн ард түмний юуны тухай бодож байгааг, мөн хэрхэн сэтгэж байгааг илтгэнэ. Учир нь хэлний үг бүтэх ёсонд үг бүтэх, үг хувилах зүй тогтол аль аль нь хамаарна.

Үг хувилах ёс нь ижил язгуурт үгээс шинэ хэлбэр бүтээдэг бол үг бүтэх ёс нь шинэ үг бүтээдэг. Энэ нь үг хувилах, үг бүтэх хоёрын гол ялгаа юм.⁶

Монгол хэлний үг бүтэх ёсны судлал нь арвин баялаг уламжлалтай. Монгол Улсад 2022 онд хэвлэсэн *Монгол хэл судлал 15* боть бүтээлийн “Үг зүй, өгүүлбэр судлал II” ботид монгол хэлний үг зүй, өгүүлбэр судлалаар туурвисан нэг сэдэвт судалгааны бүтээл, өгүүллийг товчоолон гаргасан байна. Энэхүү бүтээл нь монгол хэл судлалын түүх гэсэн ерөнхий агуулгад зангидсан тул үг бүтэх ёсны судлалыг тоймлон гаргасан бүтээл гэж болно. Үг бүтэх ёсны судалгааны тоймыг гаргахдаа залгаврын аргаар үг бүтэх, үг нийлэх аргаар үг бүтэх (зэрэгцээ үг, угсраа үг бүтэх), бусад аргаар үг бүтэх хэмээн ангилж, тухай бүрд нь судалсан судлаачдын бүтээл туурвилыг судалгааны тойм болгон гаргажээ (Өнөрбаян ба бус, 2022: 146-160). Монгол хэлний үг бүтэх ёсны судлалаар туурвисан гадаадын монголч судлаачид, Монгол Улсын судлаачдын бүтээлийг нэгд нэгэнгүй өгүүлсэн тул бид монгол хэлний үг бүтэх ёсны судлалд холбогдох судалгааны тоймыг давтан өгүүлэхээс зайлсхийв. 2022 онд гаргасан *Үг зүй, өгүүлбэр судлал II* бүтээлд дурдагдаагүй, Ж.Ганбаатарын 2023 онд хэвлүүлсэн *Монгол хэлний дагавар байр, үүрэг, хэрэглээ* хэмээх бүтээлийг дурдаж болно. Тус бүтээлд үг бүтэх дагаврын байрын асуудлыг орчин цагийн монгол хэлний баримтад тулгуурлан судалсан байна (Ганбаатар, 2023). Ц.Өнөрбаян монгол хэлний түүхэн үг бүтэх ёс бараг судлагдаагүй учраас монгол хэлний үгийн

⁶ <https://www.differencebetween.com/difference-between-inflectional-and-derivational-morphology>

гарал зүй, ялангуяа түүхэн бүтээврийн утга, бүтцийн хувьслыг тодорхойлоход бэрхшээлтэй (Өнөрбаян, 2023: 345) гэж онцлон тэмдэглэсэн байна. Иймд үйл үг бүтээх хэдэн дагаврын утга, гарлыг түүхэн толь бичгийн баримтаар тодруулахыг зорьж байна.

Хааны бичсэн манж монгол үгний толь бичиг.

Бид монгол хэлний тайлбар толь бичгийн нэгэн содон дурсгал болох 1717 онд зохиогдсон *Хааны бичсэн манж монгол үгний толь бичиг* (Ma. *Han-i araha manju monggo gisun-i buleku bithe*, мо. *Qaγan-u bičigsen manju mongγul ügen-ü toli bičig*)-ийн баримтад тулгуурлан, үйл үг бүтээх хэдэн дагаврын утга, үүргийг тодлох гэж байна. Энэ нь 1717 онд зохиож дуусгасан толь бөгөөд тухайн үеийн монгол хэлний хэл зүйн хэв шинж, онцлогийг тод томруун тусгасан толь бичиг юм. Мөн Б. Ринчен:

Монгол хэлний шинэ цагийн толийн зүйлийг өгүүлэхэд, оршил зэрэг зүйлд заасан оны цолыг үзвэл, Энх Амгалан гэдэг манж Дайчин улсын хааны үед монгол бичгийн хүмүүс, манж нангиад бичгийн хүнтэй нийлэн зохиосон толийн зүйл бий. Байдлыг нь нягтлан үзвэл тэр үеийнхээ үг зүйн боловсролын дээд хэмжээгээр хийсэн толь гэж үзэж болох бөгөөд, зарим тайлбар зүйл нь, одоогийнхоос баахан хоцорсон байгаа нь аргагүй, орчин үеийн амьдрал, шинжлэх ухааны хөгжил нь, тэр цагаас хол ахилгүй яах вэ (Ринчен, 2012: 112) гэж тэмдэглэсэн байдаг.

Үүнд Б.Ринчений дурдсанаар тэр үеийн монгол хэлний үг зүй, үг бүтэх ёсыг нарийн тусгасан толь бичгүүд гарсны нэг нь *Хорин нэгт тайлбар толь* болой.

1717 онд зохиож дуусгасан “Хааны бичсэн манж монгол үгний толь бичиг”-ийн тухай товч танилцуулъя. Монгол толь бичгийн тухай ярихад манж монгол толь бичгийн уламжлал давхар сөхөгддөг. Тухайлбал, “хааны бичсэн” хэмээх тодотгол бүхий цуврал толь бичгүүдийн хамгийн анхны толь бичиг нь Манжийн Энх-Амгалан хааны зарлигаар 1673 оноос үүсгэж, 1708 онд (Энх-Амгалангийн 46-р он) зохиож дуусгасан “Хааны бичсэн манж үгний толь бичиг” хэмээх тайлбар толь юм. Толийн толгой үгэнд дагалдах тайлбарыг манжаар үйлдсэн ба эртний түүх болон сонгодог зохиолоос жишээ татан тайлбарт хавсаргажээ (Мөнхцэцэг, 2022: 25). Энэхүү манж үгний тайлбар толийг үндэс болгож, монгол орчуулгыг нэмэн хадсанаар 1717 онд “Хааны бичсэн манж монгол үгний толь бичиг” (Ma. *Han-i araha manju monggo gisun-i buleku bithe*, мо. *Qaγan-u bičigsen manju mongγul ügen-ü toli bičig*)-ийг боловсруулсан. Ийнхүү «хааны бичсэн» хэмээх цуврал толь бичиг гурав, дөрөв, таван хэлний толь болтлоо үргэлжилж нийт долоон толь бичиг болтлоо өргөжжээ (Мөнхцэцэг, 2022: 23-43).

Эдгээрээс монгол хэлний тайлбар тольд хамаарах нь 1717 онд хэвлэн тархаасан “Хааны бичсэн манж монгол үгний толь бичиг” (Ma. *Han-i araha manju monggo gisun-*

i buleku bithe, мо. Qaγan-u bičigsen manju mongγul ügen-ü toli bičig) юм. Энэ толийн тухайд А.Лувсандэндэв “Хааны бичсэн манж монгол үгний толь бичиг” хэмээсэн гарчгийг ч бас анхаарах хэрэгтэй. Үүнийг бусад толь бичгийн гарчигтай харьцуулан үзвээс... бусад толийг цөм “манж үгний толь бичиг” хэмээгээд, манж монгол толийг “манж монгол үгний толь бичиг” гэж нэрлэсэн нь ганцхан манж хэлийг голлосон толь биш, манж, монгол хоёрын аль алины нь толь хэмээсэн нь гарцаагүй мөн бөгөөд зохиогчид үүнийг зориуд тэмдэглэсэн (Лувсандэндэв, 1961: 368) гэжээ. Цуврал толийн “Хааны бичсэн манж монгол үгний толь бичиг”-ээс бусад нь “Хааны бичсэн манж үгний толь бичиг” (1708), “Хааны бичсэн нэмж тогтоосон манж үгний толь бичиг” (1772), “Хааны бичсэн манж, монгол, хятад үсэг гурван зүйлийн аялгуу нийлсэн толь бичиг” (1780), “Хааны бичсэн дөрвөн зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг”, “Хааны бичсэн таван зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг” (1780) хэмээн бүгд “манж үгний толь бичиг” гэсэн гарчигтай. Иймд “Хааны бичсэн манж монгол үгний толь бичиг” нь монгол толь бичгийн уламжлалд чухал байр суурь эзэлнэ. Энэхүү толийг 1717, 1743 онуудад хэвлэсэн байдаг. Энэ нь хожим “Хорин нэгт тайлбар толь” гэж алдаршсан монгол хэлний тайлбар толь юм. Тус толийн оршилд “Монгол үгийг манж үсгээр авиачлан бичиж хоёр дахь удаа байрлуулсан Хорин нэгт тайлбар толь бол орчин цагийн монгол хэлний ууган тайлбар толь болно. Бид найман хошууны өтгөс өвгөд ба бас шинийн мөргөлд ирсэн дөчин есөн хошууны засгийн монголууд, тавин долоон хошууны монголуудаас манай үл дуулах, үл мэдэх үгийг тодруулан ялгамжлан асуугаад ... үйлдэж бүтээвэй” (Хорин нэгт тайлбар толь, 1979: 2). гэж хоёр дахь хэвлэлийн оршилд тэмдэглэжээ. 1717, 1743 оны хэвлэлүүдийн ялгарах гол онцлог нь сүүлийн хэвлэл нь монгол бичгийн ижил дүрсээр тэмдэглэдэг үсгүүдийг ялгаж, дуудлагыг тодорхой болгох үүднээс тэдгээрт манж үсгийн тэмдэгтийг (дусал, бинт) нэмж, монгол үгийн дуудлагыг манж үсгээр авиачлан бичсэнд оршино (Мөнхцэцэг, 2022: 28). Энэ толийн анхны хувилбарыг Энх-Амгалангийн 47-56 (буюу 1708-1717) онд Рааш, Дэнжин, Арвидах, Сэнгэ, Арана, Сэрэн, Гэндэнжав, Самбуужу, Жионжү, Банди, Гомбо Ядам, Сохай, Дорж, Баянт зэрэг монгол хэлний мэргэжилтнүүд манж монгол хэлийг харшуулан үгсийг 280 зүйлд хуваан зохиож, 1717 онд хорин нэгэн дэвтрээр Бээжин хотноо анх удаа барлажээ. Удаах хувилбарыг Тэнгэрийг тэтгэсний 8 (буюу 1743)-р онд Банди, Наянтай, Наймандай, Шолос, Дорж, Сэрэнжэс, Жидай, Бадагт, Субдунга, Амгалан, Ундрах, Сэнгэ, Хошидай, Либү нар нэгэн тогтолцоогоор “уншихад хялбар болгох”-ын үүднээс монгол бичвэрийг манжаар галиглан тэмдэглэсэн уг толийн хоёрдугаар хэвлэл хорин нэгэн дэвтрээр гарчээ (Шагдарсүрэн, 2013: 1290). Мөн энэ толийн гар бичмэлүүд хаана, хаана хадгалагдаж буйг Э.Мөнхцэцэг тодорхой тэмдэглэсэн байна (Мөнхцэцэг, 2022: 25-34).

А.Лувсандэндэв түүхийн баримт байхгүй аваас “Хорин нэгт тайлбар толь”-ийн манж, монгол хоёрын алийг нь түрүүн, алийг нь сүүлд бичсэнийг хэлэхэд хэцүү

болжээ. Хэрэв монгол үгийг өмнө тавивал зөвхөн хоёр хэлний байр солигдохоос өөр юу ч өөрчлөгдөхгүй. Хоёр хэлийг салган бичвээс аль нэгэнд нь хор болохгүй, биеэ даасан хоёр толь болох бөгөөд аль алинд нь нөгөө хэлний нөлөө ялангуяа манж үгний тольд монгол хэлний нөлөө ихэд орсон нь мэдэгдэж амой (Лувсандэндэв, 1961: 367) гэж тодорхойлсон байдаг.

Түүнчлэн энэ толийг 1979, 2013 онуудад Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос цагаан толгойн дараалалд оруулан хэвлэн тархаасан. Бид энэ толийн 2013 оны хэвлэлд тулгуурлан, задлаг, нийлэг аргаар үг бүтэх ёсыг тайлбарлая.

1. Идэвхтэй язгуураас үйл үг бүтэх нь

Үг бүтэх ёсыг хэл зүйтэй холбодог гол зүйл бол үг бүтэх арга юм. Аливаа хэлний үг бүтэх арга, хэл зүйн арга хоёр хэв шинжээрээ адил төстэй байдаг учраас үг бүтэх нь ч задлаг, нийлэг үндсэн аргатай. Хоёр ба түүнээс дээш үгийн бүтцийн хүрээнд үгийн сангийн утга илрүүлэхийг задлаг арга (нийлмэл үг), нэг үгийн бүтцийн хүрээнд шинэ үг үүсэхийг нийлэг арга (дагаврын болон бусад арга) гэдэг. Үг бүтээх хэрэглүүрүүд нь шинэ үг бүтээхээс гадна үгийн хэл зүйн шинж, үүргийг нь давхар өөрчилдөг, мөн нийлмэл үг бүтээхдээ холбоо үг бүтэх зүй тогтолд тулгуурладаг зэргээрээ үг бүтэх ёс хэл зүйтэй нягт холбогддог (Өнөрбаян ба бус, 2022: 195). Энэхүү нийлэг аргаар үг бүтэх нь дагаврын аргаар үг бүтэх зүй тогтол юм.

Тус толь бичгийн баримтад тулгуурлан Дүүдагуул “Хааны бичсэн манж монгол үгний толь бичгийн монгол хэлний үйл үг бүтээх ёсны тухай судалгаа” хэмээх магистрын судалгааны ажлыг бичиж гүйцэтгэжээ. Энэхүү судалгааны ажил нь *Хааны бичсэн манж монгол үгний толь бичиг-ийн монгол хэлний үг бүтээх дагаврын тогтолцоо, Хааны бичсэн манж монгол үгний толь бичиг дэх монгол хэлний үйл үг бүтээх дагаврыг орчин цагийн монгол хэлнийхтэй харьцуулах нь, Хааны бичсэн манж монгол үгний толь бичгийн монгол хэлний үг нийлж, үйл үг бүтээх онцлогийн тухай* хэмээх гурван бүлгээс бүрдэж байна. Тус судалгааны ажилд үйл үг, нэр үг, дайвар үг, дүрслэх үг, аялга үгээс үйл үг бүтээх дагавар гэж авч үзжээ. Мөн хоёрдугаар бүлэгт тус толийн үйл үг бүтээх дагаврыг орчин цагийн монгол хэлний дагавартай харьцуулж, гуравдугаар бүлэгт үг нийлэх аргаар үйл үг бүтэж байгааг задлан тайлбарласан байна.

Мөн Э.Мөнхцэцэг ““Хорин нэгт тайлбар толь”-д монгол хэлний $-l\check{c}a^2$, $-ldu^2$ - $ja\gamma a^2/ \check{c}a\gamma -a^2$ бүтээврийн утгын онцлогийг тусгасан нь” хэмээх өгүүллийг бичиж нийтлүүлжээ (Мөнхцэцэг, 2017). Хэв байдлын бүтээвэр нь үг бүтэх, үг хувилгах ёсны аль алинд хамаарах бөгөөд бидний сэдэвт шууд холбогдоно.

Д.Соронзон монгол бичгийн хэлнээ үйл үг бүтээх “-ай, -ой, -ий, -гана⁴, -ги, -гина⁴, -д, -ж, -л, -лз, -на⁴, -р, -рх, -с, -т, -хир, -ц, -ч, -чил, -ш, -шаа⁴, -шир” зэрэг дагавар

буйг дурдан, тэдгээрийн утга, үүрэг, хэл зүйн харьцааг тодорхойлжээ (Соронзон, 2021: 69-90).

Монгол хэлний үйл үг бүтэх ёс, тэр дундаа дагаврын аргаар үйл үг бүтэх ёсны тухай Ц.Өнөрбаян *Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс* бүтээлийг хэвлүүлжээ. Уг бүтээлд монгол хэлний үйл үг бүтэх аргыг *чөлөөт язгуураас үйл үг бүтэх нь, чөлөөт биш язгуураас үйл үг бүтэх нь* (Өнөрбаян, 2000) гэсэн хоёр бүлэгт авч үзэв. Харин орчин цагийн үг зүйн бүтээлд *чөлөөт язгуурыг идэвхтэй язгуур, чөлөөт бус язгуурыг идэвхгүй язгуур* (Өнөрбаян ба бус, 2022: 40-41) гэж тодорхойлж байна. Үг бүтээх ба үндэс үүсгэх дагаврын өмнө тохиолдож, гадаад хэлбэрээрээ үүсмэл биш үг, үндэстэй тохирох язгуурыг *идэвхтэй язгуур* гэнэ.

Хүснэгт 1. Идэвхгүй язгуураас үйл үг бүтээх дагавар

Үйл үг бүтээх дагавар	Үг	Монгол бичиг	Утга тайлбар
“-la ⁴ ” дагавар	хогломуи	Mo. qoɣlumui	Мал тэжээврийн зэргийн юм хээр хөдөөд идэхийг хогломуй хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 2013: 381)
	хөллөж	Mo. köllüji	Голын дунд бүрэн хөлдөж явж болохыг хөллөж хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 2013: 316).
	боодолмуи боодол-	Mo. boɣudalamui, boɣudala-	Боодолд хумихыг боодолмуи хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 2013: 190).
-но (u), нө (ü) дагавар	хомномуй	Mo. qomnumui	Тэмээ тохохыг хомномуй хэмээмүй. Жич даарьтай морины ширдгийг даарины тушаа ухан огтлох ба ачааны морины ширдгийг хоёр хэсэг болгон огтолж хавтасны хажууханд хэлхэж тохохыг цөм хомномуй хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 2013: 284).
	бөөмнөлдөж	Mo. bömnülduji	Аливаа үс нэг газарт ширэлдсэнийг бөөмнөлдөж хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 2013: 207).

Хорин нэгт тайлбар тольд түшиглэн, чөлөөт язгуураас үйл үг бүтэх ёсны тухай нуршин өгүүлэхээс зайлсхийв. Хүснэгт 2-г буй олон хувилбарт (“-lo (u), lö (ü)”, -но (u), нө (ü)- дагаврыг толь бичгийн баримт болоод бичгийн хэлний баримт түшиглэн тайлбарлая.

2.1. Идэвхтэй язгуураас үйл үг бүтээх -la⁴ дагавар

Хорин нэгт тайлбар тольд идэвхтэй язгуураас үйл үг бүтээх *-ла* (*-la*) дагаврын хувилбар *le, lo (u), lii* гэсэн дагаврууд тохиолдоно. Тухайлбал, *ойлмуй* (Mo. *oyilamui*), *зүрэмлэмүй* (Mo. *jürmelemüi*) зэрэг нь *-ла²* (*-la, -le*) дагавраас бүтсэн бол *хогломуй* (Mo. *qoylumui*), *хөллөж* (Mo. *köllüji*) зэрэг үйл үг нь *-ло²* (*lo (u), lii*) дагавраас бүтжээ. Иймд бид монгол бичгийн хэлнээ идэвхтэй язгуураас үйл үг бүтээх *-ла⁴* (*la-, le, lo (u), lii*) гэсэн хувилбар дагавар байна гэж үзэв. Тухайлбал, хоглох гэдэг үгийг *Монгол хэлний их тайлбар толь*-д “мал хээр бэлчээрлэн идээшлэх” (<https://mongoltoli.mn/>) гэж тайлбарлажээ. Хорин нэгт тайлбар тольд “мал гэжээврийн зэргийн юм хээр хөдөөд идэхийг хогломуй” гэж тайлбарласан ба өвлийн улирал цас орсон үед мал харгана, бурганы хог хамж идэхийг мал хоглох гэдэг. “Хог өвс”-ийг илэрхийлсэн хог хэмээх нэр язгуурт үйл үг бүтээх *-л* (*-lo*) дагавар залгаж үйл үг бүтжээ. Иймд идэвхтэй язгуураас үйл үг бүтээх *-л* (*-lo*) дагавар буйг батлах баримт нь *хоглох* хэмээх үйл үг юм. Тус үгийг Норжин, Мөрөн нарын *Монгол хэлний толь*, Ч.Лувсанжав, Г.Гантогтох, Дармаабал нарын *Монгол бичгийн хадмал толь*-д *qoylaqu* “хоглох” (Норжин, 1999: 1402), (Лувсанжав, Гантогтох, Дармаабал, 1999: 340) гэж толилжээ. Энэ нь орчин цагт нэрээс үйл үг бүтээх *-ла* (*-la*) дагавраар сэтгэн журамласан хэрэг юм. Мөн *хөллө-* хэмээх үйл үг Хорин нэгт тайлбар тольд “голын дунд бүрэн хөлдөж явж болохыг хөллөж хэмээмүй” (Хорин нэгт тайлбар толь, 2013: 316) гэж тайлбарласан байдаг. Харин *Монгол хэлний их тайлбар толь*-д “ус татарч хөлөөр гатлан гарч болмоор болох” (<https://mongoltoli.mn/>) гэж эсрэг утгаар нь тайлбарлажээ. Гэвч голын ус хөлдөж, дээгүүр нь явж болохыг *хөллөх* гэж хэлэх бөгөөд *хөл* гэсэн нэр язгуураас үүссэн үйл үг юм. Тус үгийг Норжин, Мөрөн нарын *Монгол хэлний толь*-д *köllekü* “хөллөх” (Норжин, 1999: 1402) гэж толилжээ. Харин Ч.Лувсанжав, Г.Гантогтох, Дармаабал нарын *Монгол бичгийн хадмал толь*-д *köllükü* “хөллөх” (Лувсанжав, Гантогтох, Дармаабал, 1999: 352) гэж тохиолдоно. Иймд аливаа юмны тулгуур гэсэн утгаас утга шилжин, голын ус хөлдөж, тулгууртай болохыг гол хөллөх гэж ярих бөгөөд нэр язгуураас үйл үг бүтээх *-л* (*-lii*) дагавар буй нь батлагдаж байна. Харин *боодолмуй* хэмээх үгийн тухайд *боодол* хэмээх нэр язгуурын ард үйл үг бүтээх *-ла* (*-la*) дагавар буй нь тодорхой. Гэтэл Хорин нэгт тайлбар тольд *боодолмуй* (Mo. *bojudalamui*) гэж тохиолдоно. Хэл шинжлэлд хоёр бүтээврийн заагт ижил авиа уулзахад нэг нь сугардаг үзэгдлийг *гапнологи*⁷ гэж тодорхойлдог. Хэлэхүйд дараалан орсон ижил авиаг өгүүлэхэд төвөгтэй учир нэгийг нь хасаж хэлэх бөгөөд энэ нь хэлний хэмнэх зарчимтай холбоотой. Иймд гапнологийн хууль ёсоор *боодолмуй* (Mo. *bojudalamui*) гэж тэмдэглэжээ.

⁷ Гапнологи гэдэг нь ижил авиа бүхий үс давхарлан ороход нэг нь хураагдах авианы хувьсал юм. Энэ нь диссимляцийн нэг төрөл юм. Хамгийн сайн тохирох жишээг дурдвал эртний англи хэлний Anglaland гэх үг орчин цагийн англи хэлнээ England болж хураагджээ. Мөн гапнологи (грек хэлний энгийн, ганц гэх үгээс гаралтай) хэмээх нэр томъёог Америкийн хэл шинжээч Маурис Блүүмфилд (Америкийн хэл бичгийн сэтгүүл, 1896) анх нэвтрүүлжээ (<https://www.thoughtco.com/haplology-phonetics-term-4083268>)

2.2. Идэвхтэй язгуураас үйл үг бүтээх *-на*⁴ дагавар

Хорин нэгт тайлбар тольд идэвхтэй язгуураас үйл үг бүтээх *-на* (*-na*) дагаврын хувилбар *-ne*, *-no* (*ni*), *-nii* гэсэн дагавар тохиолдоно. Тус тольд буй зүсэмнэмүй (Mo. *jūsümnemüi*), шугамнамуй (Mo. *šuyumnamui*) зэрэг үгийн утга тайлбар (Хүснэгт 2)-аас үзвэл зүсэм, шугам зэрэг нэр язгуураас үйл үг бүтээж буй нь илэрхий. Энэ нь орчин цагийн монгол хэлний зүсэх, шугамдах зэрэг үгтэй утгын хувьд тохирно. Харин *хомномуй* (Mo. *qomnumui*), *бөөмнөлдөж* (Mo. *bömnöldöj*) зэрэг үгэнд *-но*² (*-no* (*u*), *-nii*) гэсэн үйл үг бүтээх дагавар тохиолдоно. Хом гэдэг нь тэмээ ачаалахад зоо нурууг нь хамгаалж бамбайлан нөмөргөх эсгий (<https://mongoltoli.mn/>) гэсэн утгатай идэвхтэй нэр язгуур. Иймд бид монгол бичгийн хэлнээ идэвхтэй язгуураас үйл үг бүтээх *-на* *-ne*, *-no* (*ni*), *-nii* гэсэн хувилбар дагавар байна гэж үзлээ. Тус үгийг Норжин, Мөрөн нарын *Монгол хэлний толь*, Ч.Лувсанжав, Г.Гантогтох, Дармаабал нарын *Монгол бичгийн хадмал толь*-д *qomnuqu* “хомнох” (Норжин, 1999: 1413), (Лувсанжав, Гантогтох, Дармаабал, 1992: 343) гэж толилжээ. Иймд идэвхтэй язгуураас үйл үг бүтээх *-но* (*ni*) дагавар буй нь батлагдаж байна. Хорин нэгт тайлбар тольд *бөөмнөлдөх* хэмээх үгийг “аливаа үс нэг газарт ширэлдсэнийг бөөмнөлдөж хэмээмүй” (Хорин нэгт тайлбар толь, 2013: 207) гэж тайлбарласнаас үзэхэд орчин цагийн *бөөгнөх* хэмээх үгтэй утгын хувьд тохирно. Энэ нь хоёр бүтээврийн заагт авиа ондооших бүтээврийн авиалбар зүйн (*бөөн+нө > бөөгнө*) үзэгдэл бөгөөд *бөөн* (Mo. *bögem ~ böm*) хэмээх үгийн төгсгөлийн *m* (*m*) гийгүүлэгч ондоошоогүй хэвээр байсан цаг үеийн баримт болж байна. Иймд нэрээс үйл үг бүтээх *-nii* дагавар байсан нь тус толийн баримтаас харагдаж байна.

3. Идэвхгүй язгуураас үйл үг бүтэх нь

Үгийн бүтцэд зөвхөн үг бүтээх дагаврын өмнө тохиолдох язгуурыг *идэвхгүй язгуур* гэнэ. Идэвхгүй язгуур нь үлэмж ерөнхий утгатай бөгөөд ямар нэг үг бүтээх дагавар авахгүйгээр нэр, үйлийн хувиллын үндэс болж чадахгүй, нэг бол дагавар авч, аль эсвэл давтаж, хоршиж, эсвэл үйл үгэнд угтуулан холбож байж утга нь тодорхой болох ба хэлний тогтолцоонд гүйцэтгэх үүрэг нь илэрдэг (Өнөрбаян ба бус, 2022: 41). Идэвхгүй язгуураас үг бүтээх дагаврын утга, үүргийг Хорин нэгт тайлбар толийн баримтаас тодруулъя.

Хүснэгт 2. Идэвхгүй язгуураас үйл үг бүтэх нь

Үйл үг бүтээх дагавар	Дагаврын үүрэг	Үг	Монгол бичиг	Утга тайлбар
“- <i>ya</i> ⁴ + <i>na</i> ⁴ ”	Кирилл бичигт “гана ⁴ ” гэж бичдэг дагавар бол утгаа “-	дагдганаж	Mo. <i>daydayanaju</i>	Хүйтэнд хатуужин чадахгүй чичрэхийг дагдганаж чичирмүй хэмээмүй. Бас

	га ⁴ +на ⁴ ” гэсэн нийлц юм (Соронзон, 2021: 75). Тус толийн баримтаас үзэхэд “гу+на”, “гэ+нэ”, “га+на” гэсэн нийлцээс бүтсэн дагавар болох нь илэрхий харагдаж байна.			догдгонон, дагдганан хэмээн холбож хэлэлцмүй. Санаа нэг. (Хорин нэгт тайлбар толь, 2013: 521).
		догдгонон дагдганан	Mo. doγduyunan	“Дагдганаж”-ийг үз.
		дэгдгэнэж	Mo. degdegenejü	Чичрэн хөдлөх байдал. Бас дэгдгэнэн дагдганан хэмээн холбож хэлэлцмүй (Хорин нэгт тайлбар толь, 2013: 534).
		агдганан хагдганан	Mo. aγdayanan qaydayanan	Агдгалцан хагдгалцан. Тачаадтал лаг лаг инээцгээхийг агдгалцан хагдгалцан инээмүй (Хорин нэгт тайлбар толь, 2013: 12).
“-ro”	Дүрслэх язгуураас үйл үг бүтээх “p” дагавар.	цоормуй	Mo. цоγurumui	Аливаа юм нүх гарахыг цоормуй хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 2013: 778).
		оормуй	Mo. оγurumui	Дарсыг аманд авч залгихгүй гаргахыг оормуй хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 2013: 79).
“-l”	Зөвхөн эгшгээр төгссөн язгуурт шууд залгана. Идэвхгүй язгуурт залгаж, тусах үйл үг бүтээнэ.	амуул	Mo. amul	Зовохгүй жаргахыг амуул хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 2013: 15).
		доголмуй	Mo. doγulumui	Сүйтгэлзэн явахыг доголмуй хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 2013: 539).

“ᠿi-”	Язгуур үндсийн төгсгөлийг үл харгалзан, шууд залгаж бичнэ (Соронзон, 2021: 77).	ховхоч	Mo. qobquᠿi	Аливаа юмыг ховхлон авахыг ховхоч хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 2013: 281).
		чалчин балчин	Mo. ᠿalᠿin balᠿin	Үг мунхаг адаг эхгүй байдал (Хорин нэгт тайлбар толь, 2013: 560).
		няцачмуй	Mo. niᠵaᠿimui	Аливаа юмыг олбос болгон хэмхчихийг няцачмуй хэмээмүй (Хорин нэгт тайлбар толь, 2013: 157).

Идэвхгүй язгуураас үйл үг бүтээх онцлог, содон дагаврыг *Хорин нэгт тайлбар толь*-ийн баримтаар жишээлэн, утга тайлбарыг хавсаргав. Тольд буй идэвхгүй язгуураас үйл үг бүтээх дагавар, дагаврын жишээ бүрийг хавсаргахаас зайлсхийж, хоёроос гурван жишээг дурдсан болно.

3.1. Идэвхгүй язгуураас үйл үг бүтээх -γa⁴ + na⁴ дагавар

Дэгдгэнэн, догдгонон, дагдганан, агдганан зэрэг үйл үг нь *дэгд, догд, дагд, агд* зэрэг дүрслэх язгуураас үүсжээ. *Дэгдгэнэн* гэдэг нь дээшлэх, дэвжих, үсэрч дэвхцэх гэсэн утгатай дэгдэх хэмээх идэвхтэй үйл язгууртай ижил үг (*homonumu*) бөгөөд “*чичрэн хөдлөх байдал. Бас дэгдгэнэн дагдганан хэмээн холбож хэлэлцмүй*” (Хорин нэгт тайлбар толь, 2013: 534) гэсэн утгатай. Дэгдгэнэн (**degde-ge+ne*), агдганан (**aγda-γa-na*), догдгонон (*doγdu-γu+na*), дагдганан (**dayda-γa+na*) зэрэг үгийн бүтцээс ажихад *γu+na* (*γu+на*), *γa+na* (*га+на*), *ge+ne* (*гэ+нэ*) гэсэн нийлмэл дагавар ажээ.

3.2. Идэвхгүй язгуураас үйл үг бүтээх -ra, -ro, -ri дагавар

Кирилл бичигт дүрслэх язгуураас үйл үг бүтээх -р дагаврын нэг л хэлбэр байдаг бол үндэсний бичигт “-га, -го, -гi” гэсэн гурван дагавар буй. Тухайлбал, *хага* хэмээх дүрслэх язгуураас *хагар* (Mo. qaγa-**ra**), *цоо* хэмээх дүрслэх язгуураас *цоор* (Mo. ᠿoγu-**ru**), *хөм, хом, бөгт* зэрэг дүрслэх язгуураас *хөмөр* (Mo. kömüri), *хомор* (Mo. qomuri), *бөгтөр* (Mo. bögtüri) зэрэг үйл үг бүтэж байна. Иймд монгол бичгийн хэлнээ дүрслэх язгуураас үйл үг бүтээх -*ra*, -*ro*, -*ri* гэсэн гурван дагавар байна.

3.3. Идэвхгүй язгуураас үйл үг бүтээх -l дагавар

Монгол бичгийн хэлнээ чөлөөт язгуураас үйл үг бүтээх -*la*, -*le*, *lo*, -*lii*, -*li* гэсэн дагавар бий. Харин идэвхтэй бус язгуураас үйл үг бүтээх -*l* дагавар буй. Амуул (Mo. amul), доголмуй (*doγulumui*), зүйлмүй (Mo. jüyilümüi), зүүлмүй (Mo. jügülmüi) зэрэг

үгийн язгуур нь идэвхгүй язгуур юм. Тухайлбал, амар (Mo. amur), амаржих (Mo. amurjiqu), амуул (Mo. amul), амгалан (Mo. amu-yul-(a)-ng) зэрэг үгийн язгуур нь *аму (Mo. amu) юм. Эдгээр үгийн язгуур нь XIV зууны үеийн монгол хэлний баримт Мукаддиммат-Ал-Адаб тольд буй amuba “амрав” (Поппе, 1938: 101) язгуур бөгөөд үйл үг бүтээх -l дагавар авч, амуул хэмээх үг бүтжээ. Мөн *доголох* хэмээх үг нь *дого- (догонцох дэгэн догон зэрэг нь нэг язгуур) хэмээх дүрслэх язгуурт, *зүйлэх* нь *зүй* (Mo. jüi-), *зүүлэх* нь (jegü) язгуурт -л дагавар залгаж бүтсэн байна.

3.4. Идэвхгүй язгуураас үйл үг бүтээх *й*- дагавар

Няцачмуй, ховхоч, чалчин балчин зэрэг жишээнээс үзэхэд идэвхгүй язгуураас -ч дагавар бүхий үйл үг үүссэн байна. Тухайлбал, няц (Mo. niču) хэмээх үйл үг нь “хэлсэн зорьсноос ухарч буцах, шантрах, мохох” гэсэн утгатай бол няц (Mo. niča) хэмээх дүрслэх язгуур нь няц бяц (Mo. niča biča) гэж хоршдог бөгөөд “тамтаггүй болтол цохих” гэсэн утгатай. Энэхүү идэвхгүй язгуураас *няцач* (Mo. ničaci) хэмээх үйл үг бүтсэн ба үүнтэй адилаар *ховх, чал, бал* хэмээх дүрслэх, дуурайх язгуураас *ховхоч, чалчин балчин* зэрэг үйл үг үүсжээ.

Дүгнэлт

Хорин нэгт тайлбар толийн баримтад тулгуурлан, үйл үг бүтээх хэдэн дагаврын утга, үүргийг тодруулав. Толь бичгийн баримтад идэвхтэй язгуураас үйл үг бүтээх “-*la*⁴” болон “-*na*⁴” дагавар тохиолдоно. Мөн орчин цагийн тайлбар толь бичгийн бичлэгтэй ч зарим тохиолдолд дүйж байна. Иймд монгол бичгийн хэлнээ идэвхтэй язгуураас үйл үг бүтээх *ла*⁴ (*la-*, *le*, *lo* (*u*), *lii*) гэсэн хувилбар дагавар буй ажээ. Мөн *хонномуй* (Mo. qomnumui), *бөөмнөлдөж* (Mo. bömnüldüji) зэрэг үгэнд -*но*² (-*no* (*u*), -*nii*) гэсэн үйл үг бүтээх дагавар тохиолдоно. Тус хоёр үгийн язгуур нь цөм идэвхтэй язгуур билээ.

Идэвхгүй язгуураас үйл үг бүтээх дагаврыг Хорин нэгт тайлбар толиос тодлоход бичгийн хэлний баримттай яв цав тохирох бөгөөд “-*gina*” дагавраас ялгаатай “-*ya*⁴ + *na*⁴” гэсэн нийлмэл дагавар буй нь батлагдаж байна. Мөн дүрслэх язгуураас үйл үг үүсгэх “-*ra*, -*ro*, -*ri*”, -*l*, -*či* гэсэн дагавар буй. Эдгээрийг толь бичиг болоод бичгийн хэлний баримттай харьцуулан тайлбарлав.

Монгол хэлний дагавар нь үгийн сан, хэл зүйн хосолмол утгатай. Иймд орчин цагийн монгол хэлний баримтад тулгуурлан, хам цагийн үүднээс дагаврын утга, үүргийг тодорхойлох нь учир дутагдалтай. Хорин нэгт тайлбар толь 1717 онд зохиогдсон тул дагаврын эртний утга, хэлбэрийг хадгалсан баримт хэрэглэгдэхүүн гэж болно.

Монгол хэлний дагаврын эртний утга, үүргийг тодруулах нь түүхэн үг бүтэх ёсонд хамаарах бөгөөд үгийн бүтэц, гарлыг тодорхойлоход чухал ач холбогдолтой.

Clarifying the Meaning of Suffixes to Form Verbs in the Explanatory Dictionary in 21 Volumes

Erdenetuya Purevdorj

Ph.D, Associate Professor, Department of Mongolian Language, Mongolian National University of Education, Ulaanbaatar, Mongolia

Uzegulen Ulzii

Ph.D Student, Department of Mongolian Language, Eren Hot International School, Inner Mongolia Normal University, Hohhot, China

Abstract: In this article, based on the documents of the first explanatory dictionary of the Mongolian language, the Twenty-One Dictionary (1717), the characteristics and odd endings of Mongolian verb formation are explained from the point of view of word structure and typology. Verb formation in modern Mongolian can be divided into two categories: forming verbs from free roots and forming verbs from non-free roots. According to the documents of the twenty-first glossary, the variants of “-la” suffix “-lo (u)”, “-lü” suffix, “-na” suffix “-no (u)”, “-nü” to form verbs from free roots are The unique suffixes are explained by quoting from the dictionary. Also, the suffixes “-ra, -ro, -ri”, “-γa⁴ + na⁴”, “-l”, “-či-” used to create verbs from non-free roots are analyzed and explained by word structure.

Keywords: Explanatory dictionary in 21 volumes, verb, verb conjugation, free radicals, non-free radicals, suffix, sequel version

Ном зүй

- Ганбаатар, Ж. (2023). *Монгол хэлний дагавар: байр, үүрэг, хэрэглээ*. Улаанбаатар: Хэвлэлийн газар үгүй.
- Лувсанжав, Ч., Гантогтох, Г., Дармаабал. (1992). *Монгол бичгийн хадмал толь*. Улаанбаатар: Монгол бичгийн хэвлэлийн хороо.
- Мөнхцэцэг, Э. (2017). “Хорин нэгт тайлбар толь”-д монгол хэлний -lca2, -ldu2 -ja a2/ᠰаᠭ-а2 бүтээврийн утгын онцлогийг тусгасан нь. *Хэл зохиол судлал* X (42), 96-115.
- Норжин, Ц., Мөрөн, М. (1999). *Монгол хэлний толь*. Хөххот: ӨМАХХ.
- Өнөрбаян, Ц. (2000). *Орчин цагийн монгол хэлний үйл үг бүтэх ёс*. Улаанбаатар: Хэвлэлийн газар үгүй.
- Өнөрбаян, Ц., Жумдаан, Л., Саруул-Эрдэнэ, М., Ганбаатар, Ж. (2022). *Үг зүй*. Улаанбаатар: Соёмбо.
- Өнөрбаян, Ц., Самбуудорж, О., Цог-Очир, А., Мөнгөнцэцэг, Б., Ганбаатар, Ж., Энхбадрах, С. (2022). *Үг зүй, өгүүлбэр судлал*. Улаанбаатар: Соёмбо.
- Өнөрбаян, Ц. (2023). Монгол хэлний үг бүтэх ёсны судлалын тулгамдсан зарим асуудал. *Монгол хэл, бичгийн судлал, сургалт*. Улаанбаатар: Соёмбо принтинг. 341-346.

- Поппе, Н. (1938). *Монгольский словарь Мукаддиммат-Ал-Адаб*. Москва: Издательство Академий Наук СССР.
- Ринчен, Б. (2012). Монгол бичгийн хэлний зүй тэргүүн дэвтэр [удиртгал] *Эрдэм шинжилгээний бүтээлийн чуулган V боть*. Улаанбаатар: Адмон.
- Соронзон, Д. (2021). *Монгол бичиг үгийн бүтэц, дүрэм, дасгал, тайлбар*. Улаанбаатар: Арвай бархан.
- Хорин нэгт тайлбар толь*. (1977). Хөххот: ӨМАХХ.
- Хорин нэгт тайлбар толь*. (2013). Хөххот: ӨМАХХ.
- Цог-Очир, А. (2018). Монгол хэл зүйн байгуулалд туссан монгол хүний сэтгэлгээний онцлог. *Монгол-орос хэл шинжлэлийн түүвэр*, 427-442.
<https://mongoltoli.mn/>
<https://www.differencebetween.com/difference-between-inflectional-and-derivational-morphology>
<https://www.thoughtco.com/haplology-phonetics-term-4083268>